

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 19-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны санхүүгийн төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.1 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2025 оны санхүүгийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн ... тогтоолын хавсралт
2025 оны СЭНДЛИ ББСБ-ЫН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Үзүүлэлт		2025 Q1	2025 Q2	2025 Q3	2025 Q4
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,728,000,538.29	3,906,747,769.24	4,656,514,211.03	6,430,890,030.51
2	Зээл (цэвэр дүнгээр)	91,879,880,347.88	96,838,548,309.30	102,237,023,713.05	109,013,292,585.83
	Зээлийн багц (Нийт)	95,254,175,767.14	100,290,791,414.39	105,768,998,972.69	112,625,000,000.00
	Хэвийн зээл	88,660,288,006	93,548,869,864	98,831,457,800	105,491,839,205
	Анхаарал хандуулах	1,335,653,295	1,395,653,295	1,455,653,295	1,515,653,295
	Чанаргүй зээл	5,258,234,466	5,346,268,256	5,481,887,878	5,617,507,500
	Хэвийн бус зээл	1,182,507,932	1,209,869,786	1,252,697,035	1,295,524,284
	Эргэлзээтэй зээл	2,078,311,225	2,112,810,953	2,166,345,014	2,219,879,076
	Муу зээл	1,997,415,310	2,023,587,517	2,062,845,829	2,102,104,141
	Зээлийн эрсдэлийн сан	-3,374,295,419	-3,452,243,105	-3,531,975,260	-3,611,707,414
3	Үндсэн хөрөнгө	805,150,929	851,230,525	920,349,920	989,469,314
4	Бусад хөрөнгө	6,828,399,892	6,182,567,047	6,538,807,759	7,846,579,284
	Зээл, мөнгөн хөрөнгөд хур.тооцсон хүүгийн авлага	4,748,880,415	3,999,980,015	4,273,095,103	5,614,899,845
	Авлага	1,243,683,235	1,326,364,540	1,389,103,915	1,334,684,447
	Бусад	835,836,242	856,222,492	876,608,741	896,994,991
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	104,241,431,708	107,779,093,651	114,352,695,603	124,280,231,214

Үзүүлэлт		2025 Q1	2025 Q2	2025 Q3	2025 Q4
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	27,688,162,420	29,398,737,321	29,107,252,003	30,026,971,821
2	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	19,700,000,000	21,500,000,000	25,575,000,000	28,975,000,000
	Банкнаас авсан зээл	15,500,000,000	14,500,000,000	13,500,000,000	15,500,000,000
	Гадаадын банк, санхүүгийн байгууллага	4,200,000,000	7,000,000,000	12,075,000,000	13,475,000,000
3	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	15,000,000,000	15,000,000,000	15,000,000,000	15,000,000,000
4	Бусад өр төлбөр	5,231,300,841	4,388,647,650	4,105,247,703	5,033,751,735
	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,760,581,386	1,828,296,055	1,929,868,058	2,031,440,061
	Бусад санхүүгийн өр төлбөр	2,116,429,758	2,140,009,713	2,175,379,645	1,710,749,578
	Татварын өглөг	1,354,289,697	420,341,883	0	1,291,562,096
5	Нийт өр төлбөр	67,619,463,261	70,287,384,971	73,787,499,706	79,035,723,556
6	Өөрийн хөрөнгө	36,621,968,447	37,491,708,680	40,565,195,897	45,244,507,658
	Энгийн хувьцаа	11,178,500,000	11,178,500,000	11,178,500,000	11,178,500,000
	Нэмж төлөгдсөн капитал	6,284,799,653	6,284,799,653	6,284,799,653	6,284,799,653
	Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг, алдагдал	16,641,246,354	14,939,878,654	14,939,878,654	14,939,878,654
	Тухайн үеийн ашиг, алдагдал	2,501,891,555	5,070,411,007	8,140,015,503	12,815,444,543
	Бусад өөрийн хөрөнгө	15,530,885	18,119,366	22,002,087	25,884,809
	ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	104,241,431,708	107,779,093,651	114,352,695,603	124,280,231,214

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн .. тогтоолын хавсралт

2025 оны СЭНДЛИ ББСБ-ЫН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үзүүлэлт	Q1	Q2	Q3	Q4
1 Хүүгийн орлого	8,094,329,048	16,112,517,733	25,646,834,903	37,685,336,346
Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого	14,607,597	29,215,194	43,822,791	58,430,388
Зээлийн хүүгийн орлого	8,079,721,451	16,083,302,539	25,603,012,112	37,626,905,958
2 Хүүгийн зардал	2,914,295,543	5,771,574,360	8,911,682,435	12,232,761,614
Итгэлцэлийн хүүгийн зардал	1,279,344,132	2,592,782,948	3,927,070,190	5,315,786,869
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн	922,451,412	1,753,791,412	2,847,112,245	4,066,974,745
Өрийн бичгийн хүүгийн зардал	712,500,000	1,425,000,000	2,137,500,000	2,850,000,000
3 Цэвэр хүүгийн орлого	5,180,033,505	10,340,943,373	16,735,152,468	25,452,574,732
4 Хүүгийн бус орлого	1,068,235,914	2,063,821,301	3,230,249,197	4,410,569,151
Гадаад валютын арилжааны орлого	35,512,600	71,025,201	124,294,101	177,563,002
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	82,748,850	165,497,700	289,620,976	413,744,251
Зээлийн үйлчилгээний шимтгэл, хураамж	776,786,333	1,480,922,138	2,210,175,662	2,953,321,243
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлого	173,188,131	346,376,262	606,158,459	865,940,655
5 Хүүгийн бус зардал	3,302,644,744	6,512,726,326	9,731,939,568	13,147,158,644
Гадаад валютын арилжааны зардал	18,294,337	36,588,674	64,030,179	91,471,684
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	99,360,085	198,720,170	347,760,298	496,800,426
Боловсон хүчний холбогдолтой зардал	1,595,441,250	3,065,028,750	4,534,616,250	6,229,203,750
Үйл ажиллагааны зардал	1,589,549,072	3,212,388,732	4,785,532,842	6,329,682,785
6 Цэвэр хүүгийн бус орлого	(2,234,408,830)	(4,448,905,025)	(6,501,690,371)	(8,736,589,494)
7 Болзошгүй эрсдэлийн зардал	165,745,169	331,490,339	580,108,093	828,725,847
Зээлийн эрсдэлийн зардал	165,745,169	331,490,339	580,108,093	828,725,847
8 Татварын өмнөх ашиг, алдагдал	2,779,879,505	5,560,548,010	9,653,354,004	15,887,259,391
9 Орлогын татварын зардал	277,987,951	490,137,002	1,513,338,501	3,071,814,848
10 Татварын дараах ашиг, алдагдал	2,501,891,555	5,070,411,007	8,140,015,503	12,815,444,543

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 2 сарын 18-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 28 дугаар “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоол, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.8 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.8.6 дахь заалт, Ногдол ашгийн бодлогын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн 2024 оны татварын дараах цэвэр ашгаас 20,01 хувийг буюу 1,701,367,700.00 /нэг тэрбум долоон зуун нэг сая зуун гурван жаран долоон мянга долоон зуу/ төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээг 7.61 /долоон төгрөг жаран нэгэн мөнгө/ төгрөгөөр тогтоосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдрөөр тогтоосугай.
4. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2024 оны 4 дүгээр сарын 10-ний өдөр олгосугай.
5. Ногдол ашиг хуваарилж, олгох тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашгийг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгох ажлыг зохион байгуулах, ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 19-ны өдөр

№ 06

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн 8 дүгээр зүйлийн 8.6.13, 8.6.14 дэх заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 14 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, жуулчны гудамж, Артхаус оффисийн 6-н давхарт танхим болон цахим хосолсон хэлбэрээр зарлан хуралдуулсугай.
2. Хурал зарлах тухай мэдэгдлийг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид, 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн дотор Хувьцаа эзэмшигчид үйлчилж байгаа Үнэт цаасны компаниудад тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2025 оны 3 дугаар сарын 12-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг хуулийн хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д үүрэг болгосугай.
6. Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Наранбат-г томилсугай.
7. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:
 - 7.1. Хурал зохион байгуулах комиссын дарга: Д.Баярбат
 - 7.2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд: Х.Ичинхорлоо, Т.Энхбаяр
8. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
 - 8.1 Хурлын тооллогын комиссын дарга: А.Итгэлт
 - 8.2 Хурлын тооллогын комиссын гишүүд: Н.Энхчимэг, Б.Батжаргал
9. Хурлаар танилцуулах болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг Хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарыг Гуравдугаар

хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг Дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн саналыг саналын хуудсаар хүлээн авах эцсийн хугацааг 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 16:00 цаг байхаар тогтоосугай.
11. Хувьцаа эзэмшигчдийг Хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс /Д.Баярбат/-д даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтыг цахим хэлбэрээр явуулах, үүнд санал хураалтад оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр гүйцэтгэх, хуралд оролцогч бүрийн өгсөн саналыг хэвлэж, үнэн зөв болохыг баталгаажуулж, компанид хүлээлгэж өгөх үүрэг хүлээх зохих туршлага бүхий мэдээллийн технологийн компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 18-ны өдөр

№ 07

Улаанбаатар хот

“Мэдээллийн аюулгүй байдлын бодлого”-ыг шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох хэсгүүдийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн “Мэдээллийн аюулгүй байдлын бодлого”-ыг хавсралтаар шинэчлэн батласугай.
2. Энэхүү бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү бодлогыг шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 тогтоолын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлын бодлого”-ыг хүчингүйд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ





МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

“Сэндли ББСБ” ХК /цаашид “Сэндли” гэх/ нь эрх бүхий этгээдээс олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллагын хувьд дотоод, гадаад харилцагчдын мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах зорилгоор энэхүү баримт бичгийг шинэчлэн боловсруулав.

Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын бичиг баримтыг боловсруулахдаа ISO/IEC 27001:2022 Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандартыг баримталж шинэчлэн боловсруулав.

Хоёр. Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

- 2.1. Сэндли нь дараах аюулгүй байдлыг хангаж ажиллана. Үүнд:
 - 2.1.1. харилцагчид үзүүлж буй бүх төрлийн санхүүгийн үйлчилгээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
 - 2.1.2. мэдээллийн аюулгүй байдлын сайн соёлыг байгууллагад бий болгох;
 - 2.1.3. Сэндли нь харилцагчид, хөрөнгө оруулагчид, технологийн түншүүд, гуравдагч талуудтай хамтран ажиллахдаа мэдээллийн нууцлал, түүний бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлыг бүрэн хангах.
- 2.2. Кибер аюулгүй байдлыг хангаж, хэрэглэгчийн найдвартай түнш байж ёс суртахууны болон хууль ёсны хариуцлагыг сахин хамгаална.
- 2.3. Сэндлигийн бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, өгөгдөл, оюуны өмч, хөрөнгө оруулагч, хувь хүний мэдээллүүд бүгд үнэ цэн бүхий хөрөнгөд тооцогдох бөгөөд уг мэдээлэл устах, алдагдах, гадны халдлагад өртөх гэх мэт болзошгүй эрсдэлээс сэргийлж, эрсдэлийг бууруулж ажиллана.
- 2.4. Мэдээллийн аюулгүй байдал /цаашид “МАБ” гэх/-ыг хангаж, МАБ-ын удирдлагын тогтолцооны тохиромжтой, хангалттай, үр нөлөөтэй байдлыг 2 жил тутам хянаж, тасралтгүй сайжруулж ажиллана.

Гурав. Мэдээллийн аюулгүй байдлын зорилго

- 3.1 МАБ-ын бодлогын хүрээнд дараах зорилгуудыг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:
 - 3.1.1 МАБ-ын бодлогын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь журам, заавраар зохицуулагдсан байх бөгөөд ISO 27001:2022 стандартыг хангасан байгууллага байна. Үүнд:
 - 3.1.1.1. Мэдээлэл, өгөгдөл болон түүнтэй холбоотой үйл явц, мэдээллийн технологийн систем, сүлжээ нь Сэндлигийн өмч бөгөөд компанийн бусад өмчийн нэгэн адил хамгаалагдаж байна.
 - 3.1.1.2. Сэндлигийн харилцагч, хөрөнгө оруулагч, технологийн түншүүд, бусад хамтрагч байгууллагуудын мэдээлэл бүрэн бүтэн байх шаардлагын дагуу мэдээллийг дамжуулах, боловсруулах явцад үүсч болох санамсаргүй болон санаатай өөрчлөлтүүдийг хянадаг тогтолцоотой байх бөгөөд гарч болох эрсдэлийг тогтмол бууруулж ажиллана.
 - 3.1.1.3. Мэдээлэл, мэдээллийн технологийн систем нь халдашгүй, нууцлалтай байна. Мэдээлэл, мэдээллийн технологийн систем нь нууцын зэргээр ангилагдах бөгөөд эрх олгогдоогүй этгээдэд хаалттай, хандах боломжгүй байж, хууль бус хандалтаас хамгаалагдан шифрлэгдсэн байна.

3.1.1.4. Сэндлигийн мэдээлэл хүртээмжтэй байна. Мэдээлэл, мэдээллийн технологийн системүүд нь нууцын зэргээр ангилагдаж эрх бүхий этгээд цаг алдалгүй хандах, ашиглах боломжтой байна.

3.1.1.5. Сэндлигийн мэдээллийн технологийн систем, сүлжээний дэд бүтцэд нэвтэрч буй нийт хэрэглэгчдэд, хандах эрх олгогдож, сүлжээнд адилтган танигддаг байна. Сүлжээний дэд бүтцэд хандах эрх нь хяналтад байна.

3.2 Энэхүү бодлогын биелэлт, техник технологийн дэвшлийг харгалзан шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд компанийн ТУЗ-ийн тогтоолоор батална.

4 Мэдээллийн аюулгүй байдлын зорилт

4.1. Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хүрээнд дагаж мөрдөх журам, заавар, төлөвлөгөөг Сэндлигийн нийт ажилтнууд танилцан өдөр тутмын ажилд хамаарах хэсгүүдийг дагаж мөрдөж ажиллана.

4.2. Сэндли нь ажилтнуудын МАБ-ын сургалтанд хамрагдсан байдлыг 100 хувьд хүргэж ажиллана.

4.3. Сэндли нь МАБ-ын эрсдэлийн үнэлгээг жил бүр, томоохон өөрчлөлт хийх бүрт тухай бүр хийж байгууллагын эрсдэлийг бага түвшинд байлгана.

4.4. МАБ-тай холбоотой зөрчлийн шийдвэрлэлтийг бүрэн шийдвэрлэж байна.

Тав. Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хамрах хүрээ

5.1 Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хүрээнд мэдээлэл, мэдээллийн технологийн систем нь дараах агуулгыг хамрана.

5.1.1 Мэдээлэл нь:

5.1.1.1. Сэндлигийн эзэмшлийн, ашигладаг, санхүүжүүлсэн бүхий л төрлийн мэдээлэл;

5.1.1.2. Сэндлигийн оюуны өмчид хамаарах бүх төрлийн мэдээлэл,

5.1.1.3. Хэрэглэгч, хөрөнгө оруулагч, технологийн түншүүд, гуравдагч талуудад дамжуулж буй мэдээлэл,

5.1.1.4. Компанийн үйл ажиллагаа явуулахад ашиглагдаж буй бусад бүх төрлийн мэдээллийг ойлгоно.

5.1.2 Мэдээллийн технологийн систем нь:

5.1.2.1. Сэндлигийн эзэмшлийн, захиалгын, ашигладаг, санхүүжүүлсэн бүх төрлийн мэдээллийн систем, түүний дэд бүтэц, програм хангамж, үйлчилгээ, бүх төрлийн сүлжээ, холболт, компьютерээр удирдагддаг төхөөрөмж, нөөцүүд, тэдгээрийг хөгжүүлэхтэй холбогдсон аюулгүй байдлын үйл ажиллагаа.

5.1.2.2. Тухайн компанид хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн мэдээлэл, МТ-ийн системийг ойлгоно.

5.1.3 Хүний нөөц:

5.1.3.1. Компанийн эзэмшлийн мэдээлэл, МТ-ийн систем дээр ажиллаж байгаа хэрэглэгчийг ойлгоно.

5.1.4 Биет орчин:

5.1.4.1. Сэндлигийн үйл ажиллагаа явуулж буй оффисын барилга, салбар нэгжүүдийн байршиж буй байршил;

5.1.4.2. Дата төв, компьютер, бүх төрлийн техник хангамжийг ойлгоно.

5.2 Сэндлигийн хэрэгжүүлж буй төслүүдэд төслийн төрлөөс үл хамааран мэдээллийн аюулгүй байдал хэрэгжинэ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 18-ны өдөр

№ 08

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, “Хайпэй” ХХК-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компани нь Хайпэй ХХК-тай шимтгэлийн орлого хуваах нөхцөлтэйгээр “Paysend үйлчилгээний гэрээ” буюу сонирхлын зөрчилтэй хэлцлийг 2 жилийн хугацаатайгаар байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын 1-д дурдсан эрх хэмжээний хүрээнд сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 *25* оны *02* сарын *18*-ны өдөр

№ *05*

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, “Хайпэй” ХХК-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компани нь Хайпэй ХХК-тай “Нууцлалын гэрээ” буюу сонирхлын зөрчилтэй хэлцлийг 5 жилийн хугацаатайгаар байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын 1-д дурдсан эрх хэмжээний хүрээнд сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 *25* оны *02* сарын *18*-ны өдөр

№ *10*

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг чөлөөлж, шинээр томилох тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дах заалт, “Сэндли ББСБ” ХК, /цаашид “Компани” гэх/-ийн дүрмийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаас ТОГТООХ нь:

1. “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Эрдэнэгэрэлийн Цэлмэг /ШБ87021200/-ийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, 2025 оны 02 сарын 18-ны өдрөөс Баянмөнхийн Мөнхцэцэг /BE99071406/-ийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилон ажиллуулсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн би бичгийн даргатай холбогдох гэрээг байгуулсугай.

3. Компанийн дүрэм, холбогдох журмын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын үйл ажиллагааг явуулах бэлтгэх ажлыг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Мөнхцэцэг/-г даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ

